



ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТЭС



ISO 9001:2015



ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭСИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН

Орхон аймаг
2022 он



ndaatgal.or.gov.mn



orhon@ndaatgal.mn



Орхон аймгийн
Нийгмийн даатгалын хэлтэс



75776699

Нийгмийн даатгалын үйлчилгээний лавлах

НЭГ. ТАЙЛАНТ ЖИЛД ДЭВШҮҮЛСЭН БОДЛОГЫН ЗОРИЛТ, СТРАТЕГИ

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Монгол улсын хууль тогтоомж, Засгийн газрын болон аймгийн Засаг дарга бөгөөд Эрдэнэт хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсын болон аймгийн эдийн засаг, нийгмийг 2022 оны жилд хөгжүүлэх үндсэн чиглэл, УИХ, Засгийн газар, аймгийн ИТХ-аас батлан гаргасан үндэсний болон дэд хөтөлбөр, Засгийн газрын болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас батлан гаргасан тогтоол шийдвэр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал шийдвэр, аймгийн Засаг даргын захирамж зэрэг бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэн ажиллав. Энэ жилийн хувьд Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хууль Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай, Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг торгох, алдангиас чөлөөлөх тухай хуулиуд батлагдаж мөрдөгдөж эхэлснээс гадна Нийгмийн даатгалын хэлтсийн 2018-2022 оны хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд түүнд үндэслэн хэлтсийн Гүйцэтгэлийн төлөвлөгөө баталж доорх зорилгыг төлөвлөв. Үүнд:

- ✓ *Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах*
- ✓ *Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах*
- ✓ *Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах”*
- ✓ *Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах*
- ✓ *Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эмнэлэг, хөдөлмөрийн магадлах чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх*
- ✓ *Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар ажил олгогч, даатгуулагч, иргэн болон орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр*

гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах

- ✓ *Хууль тогтоомжийн хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, дүгнэлт гаргаж үйл ажиллагаа, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах”* гэсэн 8 үндсэн стратегийн бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор олон улсын чанарын удирдлагын болон дотоод аудитын тогтолцоо, эрсдэлийн удирдлагын менежмент, сайн засаглалд нийцсэн хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх, төрийн үйлчилгээний сайжруулалтын төсөл хөтөлбөрүүдийг нэвтрүүлэн чиглүүлж, судалгаа шинжилгээний дүгнэлтээр үр дүн, үр нөлөөг тооцож, хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж ажиллалаа.

Мөн Нийгмийн даатгалын хэлтэс нь ISO 9001:2015 стандартыг 2024 оны 11 дүгээр сар хүртэл дахин сунгалт хийлгэж гэрчилгээ гардан аваад байна.

Төр засгийн болон аймаг орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлтийн холбогдох зорилтыг тайлангийн хугацаанд хэрэгжүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлж чанаржуулах, хөгжлийн бодлогын хурдасгуур бий болгох, нийгмийн даатгалын үйлчилгээг хөнгөн шуурхай, чанарын түвшинг ахиулах зорилгоор доорх бодлого дэвшүүлж хэрэгжүүлэв.

Нийгмийн даатгалын байгууллагад олон улсын стандартууд нэвтрүүлэх, нийгмийн маркетингийг хөгжүүлэх, нэгдсэн бүртгэлийн систем бий болгох, роботын автоматжуулалтыг хөгжүүлэх, архивын бүртгэл, хадгалалт хамгаалалтыг автоматжуулах улмаар бүтээмжийг нэмэгдүүлэх, процессын дахин инженерчлэлийг тогтмол хийх замаар мэдээллийн технологи, техникийн дэвшилтэй уялдуулан автоматжуулалт, хиймэл оюун ухаанд суурилсан Цахим засаглалын суурийг тавьснаар Нийгмийн даатгалын бүх төрлийн үйлчилгээг нэг байцаагчаас шат дамжлагагүй авах боломжийг бүрдүүлж хэвшүүллээ. Ингэснээр иргэн төвтэй Төрийн байгууллагын ил тод байдал, бүтээмжийг дээшлүүлэн инновацийн бодлогыг стратегийн түвшинд үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр төрийн үйлчилгээний шат дамжлагыг халлаа.

Энэхүү ажлын хүрээнд өөрсдийн санаачлагаар дараах шинэлэг, инновац бүхий төсөл, хөтөлбөр үйл ажиллагаануудыг энэ оны гол зорилт болгон амжилттай хэрэгжүүллээ. Тус хэлтэс нь стратегийн зорилтын хүрээнд:

Иргэн төвтэй төрийн үйлчилгээний байгууллагын дотоод процесс үйл ажиллагааг цахим хэлбэрт оруулах, хийгдсэн ажил бүрийн нэгдсэн бүртгэлийн системийг бий болгох, CRM буюу байгууллагын иргэдэд чиглэсэн цахим системүүдийг бий болгоход чиглэсэн цогц програм хангамж болон технологийн дэмшилтэд шийдлүүдийг хамруулсан цогц төсөл хэрэгжүүлж байна.

Нийгмийн даатгалын Ерөнхий газраас 2022 оныг “ Эрх зүй-Мэдээллийн технологийн 80” жил болгон зарласантай уялдуулан Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс 3 зорилт 12 арга хэмжээ төлөвлөн ажиллаж 100 хувийн гүйцэтгэлтэй ажиллалаа.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, даатгуулагч нарт үзүүлэх үйлчилгээг хуулийн хүрээнд хэрэгжүүлэн ажиллаж Иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын байгууллагаас үзүүлэх бүх төрлийн үйлчилгээг нэг дороос шуурхай, хүлээгдэлгүй хүргэх зорилгоор үйлчилгээний нэг цэгийг 2018 оноос эхлүүлэн ажилуулж, үйлчилгээний шинэ арга барил, санаачлагыг нэвтрүүлэн хөгжүүлэлтийг хийн ажиллаж байна.



Жаргалант сумын
улсын байцаагч

Нэг цонхны үйлчилгээний
төвийн байцаагч



2022 оны жилийн эцсийн байдлаар 35799 даатгуулагчид нийгмийн даатгалын сангийн үйлчилгээг үзүүлж, 138.9 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж төлбөр олгосон.

ХОЁР. ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД

Монгол улсын Засгийн газрын “Тэтгэврийн хэмжээ нэмэгдүүлэх тухай” 63 дугаар тогтоолын хэрэгжилт: Монгол улсын Засгийн газрын 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 63 дугаар тогтоолын дагуу 16287 тэтгэвэр авагчид 2 тэрбум /сард/ төгрөгийн нэмэгдэл тооцож, 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдөр бүрэн олгосон. 2022 оны нэгдүгээр хагас жилд 10 тэрбум төгрөгийн тэтгэврийн нэмэгдлийг хуулийн хугацаанд олгосон. Тэтгэвэр авагч нараас ямар нэгэн гомдол гараагүй.

Дунд мэргэжлийн ажил хөдөлмөр эрхлэж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийн нэмэгдэл нь нөхөн даатгал хийгдсэн болон МУЗГ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор тэтгэврийн доод хэмжээ авч байсан тэтгэвэр авагчдын нэмэгдлээс бага хэмжээтэй байгаад сэтгэл дундуур байгаа тухай санал 13 тэтгэвэр авагчаас ирсэн.

УИХ-ын чуулганы 2022.04.29-ний өдрийн “Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хууль, ЗГ-ын

230 дугаар тушаалын дагуу Нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох журмыг хэрэгжүүлэн ажиллаж нөхцөл хангасан 44895 даатгуулагчдын 1 697,0 сая төгрөгийн буцаан олголтын мэдээлэлд дансны мэдээллийг бүртгэлжүүлэхэд банкуудтай хамтран ажиллаж илүү олгосон 15 даатгуулагчийн шимтгэлийг нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллалаа. Аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг хуулийн хугацаанд хүлээн авч нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэсэн аж ахуйн нэгж байгууллагын өр авлагын барагдуулан ажиллаж шимтгэлийн буцаан олголтыг олгох нөхцөлийг ханган ажиллаж байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно гэж заасны дагуу НДЕГ-ын 2022 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 06/1234 тоот албан бичгийн дагуу хэлтсийн суудлын авто машиныг зам тээврийн хөдөлгөөнд оруулахыг зогсоож албан хэрэгцээнд ашиглахаа больсон ба тус хугацаанаас хойш тээвэр шатахууны 412.300 төгрөгийн зардлыг хэмнэн ажилласан байна.

Малчин-даатгуулагчид өндөр насны тэтгэвэр тогтоох ажлын хүрээнд: Орхон аймгийн Баян-Өндөр сумын “Даатгуулагчийн малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөл” нь 3 удаа хуралдаж 4 даатгуулагч малчны мал маллаж байсан эсэх талаар шийдвэр гаргасан. Малчны зөвлөл даатгуулагчийн мал малласан хугацааг тогтоохдоо:

- ✓ Өргөдөл
- ✓ Иргэний үнэмлэхний хуулбар
- ✓ Багийн засаг даргаас тухайн иргэний малчнаар тогтоолгох гэж байгаа онуудад мал маллан амьдарч байсан эсэх тодорхойлолт
- ✓ Мал эмнэлгийн газраас гэрээтэй байсан эсэх тодорхойлолт
- ✓ Фото зураг
- ✓ Мал маллаж байсан эсэх талаар холбогдолтой баримт материалыг хавсаргаж үндэслэл болгон шийдвэрлэж ажилласан.

Орхон аймгийн Жаргалант сумын “Даатгуулагчийн малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөл” –д даатгуулагчаас хүсэлт ирээгүй болно. Тайлант хугацаанд 20 малчин-даатгуулагчид өндөр насны тэтгэвэр шинээр тогтоож, сард дундажаар 503.2 мянган төгрөгийн тэтгэвэр олгосон. Хууль хэрэгжиж эхэлснээс хойш өссөн дүнгээр 189 малчин-даатгуулагчид өндөр насны тэтгэвэр тогтоож тайлант хугацаан 188 тэтгэвэр авагчид 567.3 сая төгрөгийн тэтгэвэр олгосон байна.

Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хэрэгжилт:

Төрөөс үнэт цаасыг мөнгөжүүлэх, өвлүүлэх ажлын хүрээнд 2022 онд өв үүсгээгүй байсан иргэдийн ар гэртэй холбоо барьж, багуудын ажлын албатай хамтран мэдээлэл хүргэж, өв үүссэн иргэдийн хүсэлтийг НДЕГ-т хүргүүлж ажилласан.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН САН



Тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авч байгаа НДСОТТ-ийн тухай хуулийн хүрээнд 15.7 мянга тэтгэвэр авагчид, ЦАХТТ-ийн тухай хуулийн хүрээнд 621 алба хаагчид нийтдээ 124.8 тэрбум төгрөгийн тэтгэврийн сар бүр хуулийн хугацаанд олгосон.

Шинээр тогтоосон тэтгэвэр

Тайлант хугацаанд 1426 иргэнд шинээр тэтгэвэр тогтоосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 86 тэтгэвэр авагчаар буюу 0.06 хувиар өссөн үзүүлэлттэй байна.




График 1. Шинээр тогтоосон тэтгэвэр

Цаашид шинээр тогтоох тэтгэврийн тоо тогтворжих хандлагатай байна Тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авч байгаа 15.7 мянган тэтгэвэр авагчид нийт 124.8 тэрбум төгрөг олгосон нь батлагдсан төсвийн 98.8 хувийг зарцууллаа. Шинээр тогтоогдож байгаа тэтгэврийн дундаж дүн 768.2 мянган төгрөг байгаа нь 2021 оны шинээр тогтоосон дундаж тэтгэвэр /692.1 мянга/-ээс 11.1 хувиар өссөн байна. Энэ нь тэтгэврийн даатгалын сангийн зардал өсөх гол шалтгаан болж байна. Мөн шинээр тэтгэвэр тогтоолгож байгаа даатгуулагчдын хувьд сонгож байгаа дараалсан 7 жилийн дундаж цалингийн үзүүлэлт өмнөх оноос 1.2 функтээр өссөн нь тэтгэврийн даатгалын

сангийн зардал нэмэгдэхэд хүргэж байна. Шинээр тогтоогдож байгаа тэтгэврийн дундаж хэмжээ 768.2 мянгад хүрч байна.

Тэтгэвэр авагчийн банк сонголтын мэдээлэл

Шинээр тэтгэвэр тогтоолгосон 1426 иргэн үйлчлүүлэх банкаа өөрийн хүсэлтээр сонгосон ба хуучин тэтгэвэр авч байсан 803 иргэн банкаа соль нийт 2229 тэтгэвэр авагч үйлчлүүлэх банкаа сонгосон




График 2. Банкуудаар үйлчлүүлж буй тэтгэвэр авагчийн тоо

Сар бүрийн 25 ны өдрөөр тэтгэврийн дансаа хааж 5 банктай тооцоо нийлж олголтоо шалгаад дараа сарын файлаа банкуудад бэлтгэн өгч тэтгэврээ олгож байна. Сардаа 17.9 мянган хүнд сард 11.2 тэрбум төгрөгийн тэтгэврийг олгож, 7 хоног бүр группын сунгалт хийлгэж байгаа болон тэтгэврээ шинээр тогтоолгож байгаа иргэдэд олготыг жагсаалтаар тухай бүрд нь олгож үйлчилж байна.

Мөн тэтгэвэр авагдын өргөдөл хүсэлтийн дагуу жил нэмэх, цалин солих зэрэг үйлчилгээг хуулийн дагуу түргэн шуурхай үзүүлэн үйлчилж байна. 1419 хүсэлтийг биеэр хүлээн авч, 34 хүсэлтийг цахимаар хүлээн авч үйлчиллээ. Хэлтсийн цахим хуудасны чат бот үйлчилгээнд тэтгэвэртэй холбоотой 436 иргэний хүсэлт ирж, мэдээллээр хангаж ажилласан.

Тэтгэврийн даатгалын сангийн зардал

2022 онд аймгийн хэмжээд дундаж тэтгэврийн дүн 653.9 мянган төгрөг байна. Энэ үзүүлэлт нь 2021 оны дундажаас 27.5 хувиар өссөн. Баян-өндөр сум, Жаргалант сумуудаас 2022-2024 онуудад тэтгэврийн насанд хүрч байгаа иргэдийн нэгдсэн судалгааг авч нэгтгэхэд ирэх онуудад тэтгэвэр тогтоолгох иргэдийн тоо тогтворжих хандлагатай байна.

ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САН



Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тус онд давхардсан тоогоор 16341 иргэдэд тэтгэмж олгож 7.1 тэрбум төгрөгний хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж олгож ажилласан байна. Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 хувь буюу 195.6 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь Даатгуулагчийн тоо 774 иргэнээр буурсан боловч тэтгэмжийн олговор нь 195.6 сая төгрөгөөр өссөн нь “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын цалин өссөнтэй холбоотой.

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН САН



2022 онд тахир дутуугийн болон тэжээгчээ алдсан 466 тэтгэвэр авагчдын тэтгэвэрт 3.8 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсан 43 иргэний тэтгэмжид 42.4 сая төгрөг, хиймэл эрхтэн, протез 2 даатгуулагчид 1.0 сая төгрөг, нөхөн сэргээх зардалд 259 даатгуулагчид 186.8 сая төгрөгийн зардал тус тус зарцуулсан байна.

АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САН



2022 онд ажилгүйдлийн даатгалын сангаас 922 даатгуулагч ажлаас халагдсаны 2.6 тэрбум төгрөгийн тэтгэмж авсан байна. Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо өмнөх оноос 115 хүнээр өссөн байна.

АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ТАЛААР

2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/02 тоот дугаартай “Баримт хүлээн авах хуваарь”-ийг хэлтсийн даргаар батлуулж тасаг, албадуудаас хуваарийн дагуу баримттай хамт ирүүлсэн жагсаалтын дагуу нэг бүрчлэн тоолж, архивт хүлээн авах баримтын бүртгэл хөтөлсөн. Хүлээн авсан баримтыг зохих стандартын дагуу цахим мэдээллийн санд бүртгэж мэдээллийн санг арвижуулсан. Тус хэлтсийн:

- ✓ Санхүү бүртгэлийн тасаг
- ✓ Үйлчилгээний тасаг
- ✓ Хамралт орлого шимтгэлийн тасаг
- ✓ Хяналт шалгалтын тасгуудаас нийт байнга болон түр 70 жил хадгалах 846 баримт хүлээж авсан.

Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг батлах

Байгууллага, салбарын үйл ажиллагаанд өдөр тутам үүсч хөтлөгдөж буй баримт бичгийг зөв ангилж бүлэглэх, хадгалах хугацааг оновчтой тодорхойлох, тэдгээрийг хэрг болгон бүрдүүлэх, тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл, лавлагаанд ашиглах зорилгоор 2022 оны 01-02 дугаар саруудад байцаагч ажмлтнуудаас санал авч 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр

БНШКомисс хуралдаж “Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн Хөтлөх хэргийн жагсаалт”-ыг баталсан.

Баримт нягтлан шалгах комисс хуралдуулах

БНШК нь 2022 онд 2 болон түүнээс дээш хуралдах төлөвлөгөө гаргасны дагуу хамгийн эхний хуралаа 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр “Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн Хөтлөх хэргийн жагсаалт”-ыг баталж, хэлтсийн даргын 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/02 тоот дугаартай “Баримт хүлээн авах хуваарь”-ийн дагуу хугацаандаа тасаг нэгжүүдээс баримтаа хүлээн авч дуусгасан талаар хэлэлцсэн.

Данс бүртгэл хөтлөх

2022 онд 10 нэр төрлийн данс бүртгэл ашиглан нийт 2374 бүртгэл хийгджээ. Үүнд:

1. Ажилласан жил нөхөн тооцуулсан иргэдийн бүртгэл - 120
2. Архивын баримт түр ашиглуулсан бүртгэл - 35
3. Орхон аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн даргын тушаалаас хуулбарлан олгосон бүртгэл, Архивын хуулбар, хэсэгчилсэн хуулбар, баримтын сэдэвчилсэн жагсаалт олгосон бүртгэл - 4
4. Архивын лавлагаа олгосон бүртгэл /1995 – 2005/ - 655
5. 1991-1994 онуудад ажил олгогч байгууллага нийгмийн даатгалын шимтгэл төлж байсан тухай лавлагаа олгосон бүртгэл - 142
6. Албан байгууллагад архивын лавлагаа олгосон бүртгэл - 483
7. Архивт хүлээн авсан баримтын бүртгэл - 18
8. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааны бүртгэл /QR кодтой/ - 115
9. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааны бүртгэл /Хүсэлт явуулсан бичгийн/ - 320
10. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааны бүртгэл /Хүсэлт ирүүлсэн бичгийн/ - 138
11. Эрхийн харьцаа дуусгавар болсон тэтгэврийн хувийн хэргээс материал авсан бүртгэл – 25
12. Архивын байрны дулаан, чийгшил болон цэвэрлэгээ хөтлөх бүртгэл - 15

Нийгмийн даатгалын архивын лавлагаа олгох үйлчилгээ

2022 оны байдлаар дараах 7 нэр төрлийн нийт 1973 лавлагааг гаргаж иргэн даатгулагч, ААНБ-уудад үйлчиллээ.

1. Ажилласан жил нөхөн тооцуулсан иргэдийн лавлагаа - 120
2. Архивын лавлагаа /1995 – 2005/ - 655
3. 1991-1994 онуудад ажил олгогч байгууллага нийгмийн даатгалын шимтгэл төлж байсан тухай лавлагаа - 142


4. Албан байгууллагад архивын лавлагаа - 483
5. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааны бүртгэл /QR кодтой/-115
6. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааны бүртгэл /Хүсэлт явуулсан бичгийн/ - 320
7. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааны бүртгэл /Хүсэлт ирүүлсэн бичгийн/ - 138

Бусад аймаг, дүүрэгтэй цахимаар лавлагаа солилцох

Архив албан хэрэг хөтлөлтийн “Абле” системээр 2022 оны байдлаар

- ✓ Бусад аймаг дүүрэг рүү 320 лавлагаа захиалан авсан
- ✓ Бусад аймаг, дүүргээс 138 лавлагаа ирсэн

Нийтдээ 458 лавлагааг аймаг, дүүргийн хэлтсүүдтэй солилцсон байна.



Цахим лавлагаа

2022 оны жилийн эцсийн байдлаар 115 QR кодтой лавлагааг хэлтэс дотооддоо тэтгэвэр, тэтгэмж тогтоох, төлбөр, зардал олгоход ашигласан байна. Энэ лавлагаа нь багассан нь E Mongolia систем нэвтэрсэнтэй холбоотой бөгөөд архивын ажилтны ачааллыг эрс бууруулж байна.

Ирсэн болон явсан бичиг

Ирсэн, явсан бичгийг хүлээн авч, бүртгэлийн дэвтэрт бүртгэх ажлын хүрээнд 2022 онд тус хэлтэст нийт 672 бичиг ирсэн ба 1840 бичиг явуулсан ба тухай бүрт бүртгэж байцаагч ажилтнуудад хүлээлгэн өгч тухай бүрт шийдвэрлэж ажилласан.

Өргөдөл гомдол

2022 онд иргэд даатгуулагчдаас нийт 347 өргөдөл ирсэн ба өргөдлийг тухай бүрт бүртгэн хариуцах ажилтанд шилжүүлж шийдвэрлэлтэд хяналт тавьж ажилласан ба өргөдөл гомдлын шийдвэрлэсэн дундаж хугацаа 4 хоног байна.

ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ

№	Төрөл	Өргөдөл гомдлын ангилал	Нийт өргөдөл гомдол	НДХ
1		Нийгмийн даатгалын салбарын асуудлаар	2	2
дүн			2	2
2	Санал	Нийгмийн даатгалын салбарын асуудлаар	1	1
Санал дүн			1	1
3	Хүсэлт		1	1
4	Хүсэлт	Нийгмийн даатгалын салбарын асуудлаар	264	264
5	Хүсэлт	Эрүүл мэндийн үйлчилгээтэй холбогдолтой асуудлаар	3	3
Хүсэлт дүн			268	268
6	Гомдол	Газрын харилцааны асуудлаар /газар эзэмших болон өмчлөх, шинээр газар авахыг хүссэн ба эзэмших, ашиглах гэрчилгээ солих/	1	1
7	Гомдол	Нийгмийн даатгалын салбарын асуудлаар	2	2
8	Гомдол	Эрүүл мэндийн үйлчилгээтэй холбогдолтой асуудлаар	2	2
Гомдол дүн			5	5
9	Талархал	Нийгмийн даатгалын салбарын асуудлаар	2	2
Талархал дүн			2	2
НИЙТ ДҮН			347	347

ГУРАВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ТАЛААР

Аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн албан тоот, иргэнээс ирсэн өргөдөл, гомдол, саналын дагуу Хяналт шалгалт дотоод аудитын тасаг нь өдөр тутмын ажлуудад хуульд заасан заалт, тогтоол, шийдвэр, журамд үндэслэн шийдвэр гарган ажилласан байна. Мөн нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчиний, ажилгүйдлийн даатгалын сангуудаас олгогдож байгаа тэтгэвэр тэтгэмжид хяналт тавьж ажилласан.

1.1 Аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 279 албан тоот, хүсэлтийг хүлээн авч хуулийн дагуу зөрчлийг барагдуулан ажилласан.

- Улсын байцаагчийн акт – 105
- Улсын байцаагчийн дүгнэлтээр цалин залруулга – 85
- Улсын байцаагчийн дүгнэлтээр төрөл залруулга – 89

1.2 Иргэнээс ирсэн 57 өргөдлийг хуульд заасан хугацаанд нь шийдвэрлэж ажиллаа.


- Улсын байцаагчийн акт – 24
- Тэтгэвэр тогтоолтын үндэслэл дахин шалгах – 14
- Бусад – 19

1.3 2022 онд шинээр тэтгэвэр тогтоолгон авч байгаа 1551 тэтгэвэр тогтоолтыг тухай бүр хянан шалгаж ажилласан. Шинээр тогтоогдсон тэтгэврээс 190 зөрчил дутагдлыг илрүүлж тухай бүр нь засуулж, тэтгэвэр авагч нарт нэмж олгохоор 1,022,021 төгрөг, хасаж олгохоор 626,708 төгрөгийг шийдвэрлэж ажилласан.

№	Төрөл	Тэтгэвэр авагчийн тоо	Шинээр тогтоогдсон тэтгэврийн дүн
1	Өндөр насны тэтгэвэр	1157	1,007,389,674
2	Тахир дутуугийн тэтгэвэр	310	146,360,988
3	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	84	44,260,640
Нийт		1551	1,198,011,302


1.4 Тэтгэмжийн 2 байцаагч, үйлчилгээний хэсгийн 9 байцаагчийн тэтгэмжийн даатгалын сангаас 2022 онд давхардсан тоогоор 15654 даатгуулагчдад 6,4 тэрбум төгрөгийн тэтгэмжийг олгохоор тогтоосон байдалд хяналт шалгалт, дотоод аудитын тасгийн 4 байцаагч дахин хяналт тавьж 191 зөрчил дутагдлыг тухай бүр нь засуулж, даатгуулагчдад нэмж олгохоор 10.079.984 төгрөг, хасаж олгохоор 4,882,095 төгрөгийн тэтгэмжийг шийдвэрлэж ажилласан байна.

№	Төрөл	Тэтгэмж авагчийн тоо	Дүн
1	Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж	13762	2,689,782,353
2	Жирэмсэн амаржсаны тэтгэмж	1892	3,795,461,300
Нийт		15654	6,485,243,653



1.5 Үйлдвэрийн ослын даатгалын даатгалын сангаас 2022 онд шинээр тогтоогдон олгогдож байгаа тэтгэмжид ямар нэгэн зөрчил гараагүй байна.

№	Төрөл	Тэтгэмж авагчийн тоо	Дүн
1	Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж	43	42,274,599
	Нийт	43	42,274,599



1.6 Ажилгүйдлийн даатгалын сангаас 2022 онд шинээр тогтоогдон олгогдож байгаа ажилгүйдлийн 912 хүний 2,6 тэрбум төгрөгийн тэтгэмжид хяналт шалгалт хийж ажилласан. Хяналтаар 70 зөрчил дутагдлыг тухай бүр нь засуулж, даатгуулагчдад нэмж олгохоор 13,101,102 төгрөг, хасаж олгохоор 6,656,591 төгрөгийн тэтгэмжийг шийдвэрлэж ажилласан.

№	Төрөл	Тэтгэмж авагчийн тоо	Дүн
1	Ажилгүйдлийн тэтгэмж	912	2,644,764,493
	Нийт	912	2,644,764,493



2022 онд тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас олгогдож байгаа нийт 18160 ширхэг тогтоолт, олголтод хяналт шалгалт хийж ажилласан байна.

Нийгмийн даатгалын тухай хууль болон Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт

Улсын байцаагчийн актын 2022 оны эхний үлдэгдэл 25,1 сая төгрөг байсан. 2022 онд Хяналт шалгалт, дотоод аудитын тасгийн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт, аж ахуйн нэгж, байгууллагын албан хүсэлт, иргэдийн өргөдлийн дагуу нийт 279 байгууллагын санхүүгийн баримтад хяналт шалгалт хийж, цалин залруулгын дүгнэлт 85 байгууллага, төрөл залруулгын дүгнэлт 89 байгууллагад бичиж, ААНБ-ын санхүүгийн баримт, НД-ын сангийн зарцуулалтад хяналт шалгалт, дотоод аудит хийж 105 зөрчилд улсын байцаагчийн акт болон зөрчлийн тухай хуулийн хялбаршуулсан журмаар нийт 141,9 сая төгрөгийн НДШ, алдангийг НД-ын санд төвлөрүүлэн ажилласан. Үүнээс зөрчлийн тухай хуулиар 78 аж ахуйн нэгж, байгууллагатай холбоотой зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж хуульд заасан хугацаанд төлөгдөөгүй орхигдуулсан 41,1 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, алдангийг бүрэн нөхөн төлүүлж, зөрчилд 15,1 сая төгрөгийн торгуулийг тавьж 100 хувь бүрэн барагдуулан ажилласан.



Төлөвлөгөөт хяналт, шалгалт

2022 онд Хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь хэлтсийн даргын удирдамжийн дагуу дараах 7 чиглэлийн хүрээнд холбогдох хууль, тогтоомж, журмын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулж зөвлөмж өгч ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг бүрэн хангуулан ажилласан.



*Төлөвлөгөөт хяналт, шалгалтын дэлгэрэнгүйг
QR уншуулан үзнэ үү.*

Дээд газраас өгсөн чиглэлийн дагуу хийгдсэн хяналт шалгалт

Дээд газраас өгсөн чиглэлийн дагуу 4 төрлийн хяналт, шалгалтыг тогтоосон хугацаанд нь хийж гүйцэтгэн холбогдох газруудад мэдээ, тайланг хүргүүлж ажилласан.



Дээд газраас ирүүлсэн чиглэлийн дагуу хийсэн хяналт, шалгалтын дэлгэрэнгүй тайланг QR уншуулан үзнэ үү.

Цахим хяналт

Цахим хяналтын <http://10.9.0.5/monitoring/> программ хангамжаар илэрсэн дараах зөрчлүүдийг тухай бүр үндсэн эх баримттай тулган шалгаж, зөрчлүүдийг шийдвэрлэж ажилласан байна. Үүнд:

1. Шимтгэл-Цалин устгасан мэдээлэл (даатгуулагчаар) - 138
2. Шимтгэл-Цалин өөрчилсөн мэдээлэл (даатгуулагчаар) - 493
3. Шимтгэл-Цалин өөрчилсөн мэдээлэл (АО-оор) – 1034
4. Шимтгэл-РД нэгтгэсэн даатгуулагч – 49
5. Шимтгэл-РД зассан даатгуулагч - 1
6. Шимтгэл-НДШ төлсөн тэтгэвэр авагч (код буруу) - 302
7. Шимтгэл-даатгуулагчийн төрөл буруу – 547
8. Шимтгэл-01 код давхардсан даатгуулагч - 1346
9. Тэтгэвэр-Тэтгэвэр тогтоолгосон цалин - 0
10. ЖА тэтгэмж-Эрхийн нөхцөл хянах жагсаалт – 15
11. ЖА тэтгэмж-Цалинг хянах жагсаалт - 543
12. Ажилгүйдлийн тэтгэмж-Эрхийн нөхцөл хянах жагсаалт - 8
13. Ажилгүйдлийн тэтгэмж-Цалинг хянах Жагсаалт - 16
14. Ажилгүйдлийн тэтгэмж-Хугацаа хэтэрч бүртгүүлсэн - 20
15. Ажилгүйдлийн тэтгэмж-1 сард ажилгүйдлийн тэтгэмж, цалин давхардсан- 363 нийт 4875 даатгуулагчийн мэдээллийг 100 % шалгах зорилт тавин ажиллаж байна.

ДӨРӨВ. САНХҮҮГИЙН БҮРТГЭЛИЙН ТАЛААР

Санхүү бүртгэлийн тасаг нь тус онд Санхүү бүртгэлийн тасгийн дарга бөгөөд ахлах нягтлан бодогч, сангийн нягтлан бодогч хоёр, үйл ажиллагааны нягтлан бодогч, нярав гэсэн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж ажилласан Нийгмийн даатгалын байгууллагын болон сангийн тайланг улирал бүр нийт 4 удаа гаргаж НДЕГ-ын Санхүү бүртгэлийн газарт хянуулж баталгаажуулсан. Мөн төсвийн гүйцэтгэл, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, нэгдсэн санхүүгийн тайлангуудыг бүтэн жилээр 4 удаа хуулийн хугацаанд гаргаж хүргүүлэн баталгаажсан тайланг сангийн яамны прораммд оруулан ажиллалаа.

Эрүүл мэнд нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэлийн газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 5/841 тоот Нийгмийн даатгалын сарын мэдээ гаргахад баримтлах чиглэл албан бичгийн дагуу

- Харилцахын үлдэгдэлийг өдөр бүр 6 банкны 35 дансны хуулгыг эцсийн үлдэгдэлтэй тулган шалгаж
- Сангийн мэдээний сан тус бүрийн мөнгөн хөрөнгийн эхний, эцсийн үлдэгдэлийг харилцахын үлдэгдэл мэдээтэй тулган шалгаж
- Нийгмийн даатгалын сангийн сарын мэдээний төлөвлөгөөг шивж оруулан Сангийн мэдээний бусад орлого зарлагыг мөнгөн гүйлгээний цэвэрлэгээний тайлангийн дүнгээр цэвэрлэн нийт 6 төрлийн мэдээг 12 удаа гаргаж хэмнэлт хэтрэлтийн тайлбарын хамт дараа сарын 02-ны өдөрт багтаан сүлжээнд байршуулан, цаасаар хэвлэн авч баталгаажуулан баримт бүрдүүлж ажилласан.
- Байгууллагын урсгал үйл ажиллагааны зардлын мэдээг 12 удаа гарган өгсөн байна.
- Аймгийн статистикийн хэлтэст сар бүр сангийн орлого зарлагын мэдээг 12 удаа өгч, шилэн дансны сайтан тухай бүр, сар бүр, улирал бүр жилээр гэсэн хагас жилийн байдлаар Сангийн шилэн данс – 163 мэдээ Байгууллагын үйл ажиллагааны шилэн данс – 151 мэдээг хуулийн хугацаанд нь үнэн зөв бэлтгэн байршуулж ажилласан.

Үйл ажиллагааны зардлын зарцуулалтын талаар

Байгууллагын урсгал үйл ажиллагааны зардлыг Нийгмийн даатгалын ерөнхий газраас баталсан “Үйл ажиллагааны зардлын 2022 оны төсвийн сарын хуваарь”-ийн дагуу зардлын ангилал тус бүрээр зарцуулан ажилласан байна. Байгууллагын урсгал зардал жилээр **683.1** сая төгрөг зарцуулахаар төлөвлөгөө батлагдаж **675.6** сая төгрөгийг зарцуулан нийт 98.9 хувийн биелэлттэй ажилласан. Аймгийн ЗДТГазраас санхүүжүүлдэг Нийгмийн даатгалын төлөөлөлч хөтөлбөрт **60.0** сая төгрөгийн санхүүжилт авсан ба 10 төлөөлөгчийн цалин хөлсөнд зарцуулан ажиллалаа. Дээд шатны байгууллагаас **30.1** сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн авч данс бүртгэлд бүртгэсэн бол “Нийгмийн даатгалын хэлтсийн цахим орчинг сайжруулах” төслийн хүрээнд Орхон аймгийн Орон нутгийн өмчийн албанаас **29.8** сая төгрөгийн хөрөнгийг хүлээн авч данс бүртгэлд бүртгэсэн байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого зарлагын гүйцэтгэлийн талаар

Сангийн 2 нягтлан бодогч банкуудын харилцах дансны гүйлгээг дараа өдөр нь сан тус бүрээр тулган сангийн нэгдсэн программд мэдээллийг үнэн зөв шивж ажиллаа. Мөн гүйлгээний утга тодорхойгүй 200 гаруй даатгуулагчийн гүйлгээг тухай бүр залруулан ажилласан байна. Сангийн орлого зарлагын гүйлгээний тоо / 6 банкны 5 сан/

№	Сан/Банк	Хаан	Капитрон	Голомт	ХХБ	Төрийн сан	Төрийн банк	Нийт гүйлгээ
1	Төвлөрсөн	41115	579	2286	2192	3489	4835	49665
2	Тэтгэврийн	2957	1095	2038	327	4	2577	6423
3	Тэтгэмжийн	2176	895	1779	376	2	2873	5228
4	ҮОМШӨ	265	103	65	99		314	532
5	Ажилгүйдлийн	3411						6815
6	ЭМД	8365	13	76	147	3404	1035	18904
Нийт гүйлгээний тоо		58289	2685	6244	3141	6899	11634	87567

Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйлгээг харилцах программд шивж оруулах процесс ажиллагааг хөнгөвлөх зорилгоор RPA роботыг өдөр тутам ашиглаж байна. Уг робот автоматжуулалтыг ашигласнаар ажилтнаас 3,3 дахин хурдан бөгөөд тасралтгүй сайжруулан ажиллах байна.

Нийгмийн даатгалын сангийн орлогын сар, улирал бүрийн төлөвлөгөөний биелэлт, түүний гүйцэтгэлд бүртгэлээр хяналт тавин 2022 оны хагас жилээр 141,335.9 сая төгрөгийн шимтгэлийн орлого оруулахаас 136,817.86 сая төгрөгийн шимтгэлийн орлого оруулж 96.8 хувийн биелүүлсэн.

Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх онуудад:

- 2017 онтой харьцуулж үзвэл 53,565.6 сая төгрөгийн орлого оруулахаас 53,593.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 100,06 хувьтай.
- 2018 онд 60,868.8 сая төгрөгийн орлого оруулахаас 66,818.3 сая төгрөгийн шимтгэлийн орлого оруулж төлөвлөгөөний биелэлт 109,7 хувьтай.
- 2019 онд 66,548.7 сая төгрөгийн орлого оруулахаас 79,421.8 сая төгрөгийн шимтгэлийн орлого оруулж төлөвлөгөөний биелэлт 119.3 хувьтай тус тус биелсэн байна.
- 2019 онд 77,148.1 сая төгрөгийн орлого оруулахаас 80,434.1 сая төгрөгийн шимтгэлийн орлого оруулж төлөвлөгөөний биелэлт 104.2 хувьтай тус тус биелсэн байна.
- 2020 онд 77,148.9 сая төгрөгийн орлого оруулахаас 85,277.86 сая төгрөгийн шимтгэлийн орлого оруулж төлөвлөгөөний биелэлт 110.54 хувьтай тус тус биелсэн байна.
- 2021 онд 82,999.14 сая төгрөгийн орлого оруулахаас 102,066.67 сая төгрөгийн шимтгэлийн орлого оруулж төлөвлөгөөний биелэлт 122.97 хувьтай тус тус биелсэн байна.

Нийгмийн даатгалын сангийн орлогын сар, улирал бүрийн төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллаж 2022 онд 141 335.9 сая төгрөгийн шимтгэлийн орлого оруулахаас 136 817.86 сая төгрөгийн шимтгэлийн орлого оруулж 96.8 хувийн биелүүлсэн.

2022 оны 1407 ажил олгогч байгууллагын 28864, даатгуулагчийн 136 817.86 төгрөгийн шимтгэлийн орлогыг санд төвлөрүүлж өмнөх оны мөн үетэй харьцуулбал шинээр 112 аж ахуйн нэгж хамрагдсан байна. 2022 оны орлогыг сан тус бүрээр гарган дүгнэхэд /сая.төг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Тэтгэврийн даатгалын сан	117,351,919.00	112,560,223.00	4,791,696.00	95.92%
2	Тэтгэмжийн даатгалын сан	9,466,733.20	9,356,963.00	109,770.20	98.84%
3	ҮОМШӨ даатгалын сан	12,449,899.30	12,981,821.00	531,921.70	104.27%
4	Ажилгүйдлийн даатгалын сан	2,067,389.20	1,918,852.00	148,537.20	92.82%
Дүн		141,335,940.70	136,817,859.00	4,518,081.70	96.80%

Нийт шимтгэлийн орлогын төлөвлөгөө 141.3 тэрбум төгрөг оруулахаас 136.8 тэрбум төгрөг оруулж орлогын төлөвлөгөөг 96.8 хувиар биелүүлсэн байна.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА

Сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хугацаанд нь тооцон олгож иргэд даатгуулагчдад хөнгөн шуурхай үйлчилж ирсэн.

Нийгмийн даатгалын сангийн зардалын төсөв бүтэн жилээр 140,642.18 сая төгрөг бөгөөд гүйцэтгэл 138,959.89 сая төгрөгийн зардал гарсанаар төсөв хэтрүүлээгүй буюу 98.8 хувийн биелэлттэй гарсан.

Зардалын гүйцэтгэлийг сан тус бүрээр гарган дүгнэхэд /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Тэтгэврийн даатгалын сан	125,984,586.00	124,784,363.00	1,200,223.00	99.05%
2	Тэтгэмжийн даатгалын сан	8,083,903.10	7,521,798.27	562,104.83	93.05%
3	ҮОМШӨ даатгалын сан	4,719,047.10	4,600,529.00	118,518.10	97.49%
4	Ажилгүйдлийн даатгалын сан	1,854,644.10	2,053,203.00	198,558.90	110.71%
Дүн		140,642,180.30	138,959,893.27	1,682,287.03	98.80%

Сангийн зардал нийт дүнгээрээ хэтрээгүй байгаа боловч дээрх хүснэгтээс харахад ажилгүйдлийн даатгалын сангийн зардал батлагдсан төсвөөс хэтэрсэн үзүүлэлт гарч байна. Эдийн засгийн хямрал нөхцөл байдлас үүдэн байгууллагын үйл ажиллагаа хэвийн бус болж үүнийгээ дагаад орон тоо бууруулах, цалин хөлсийг танах асуудал нэмэгдсээр байна. Ажилгүйдлийн тэтгэмж авах иргэдийн тоо нэмэгдэх хандлагатай байгаа ба дундаж цалингийн өссөлттэй уялдан олгох тэтгэмжийн зардлын дүн мөн өсөж байна.

САНГИЙН ТӨВЛӨРҮҮЛЭЛТ, САНХҮҮЖИЛТ

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны А/121 тоот тушаалын дагуу 2022 оны хагас жилийн байдлаар зардлаас давсан орлогыг төв санд дараах байдлаар төвлөрүүлэв.

- Тэтгэврийн даатгалын санд – 8.8 тэрбум
- Тэтгэмжийн даатгалын санд – 2.3 тэрбум
- ҮОМШӨ даатгалын санд – 8.3 тэрбум нийт 19.2 тэрбум төгрөг тус төвлөрүүлсэн байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар хооронд байгуулсан 2019 оны А-02/НД47 дугаартай “Хамтран ажиллах гэрээ” -ний дагуу Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг 7 хоногийн 5 дахь өдөр бүр нийт 19.1 тэрбум төгрөгийг төв дансанд төвлөрүүллээ.

Архивын лавлагаа болон аж ахуйн нэгжийн тодорхойлолтын үнийг 2 дугаар сарын 28-ны өдөр хүртэл нийт 54985.06 төгрөгийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын төв санд бүрэн төвлөрүүлж ажиллав.



Сангийн инфографик тайланг QR уншуул үзнэ үү.

Хөндлөнгийн байгууллагуудын хийсэн хяналт шалгалтын талаар

Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын 2021 оны санхүүгийн тайланд аймгийн “Төрийн аудитын газар” аудит хийсэн. Нийгмийн даатгалын сангийн нэгдсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар “Зөрчилгүй ” санал дүгнэлт авсан. Тус санхүүгийн аудитаар 2 зөвлөмж, 3 албан шаардлага, 1 акт манай байгууллагад хүргүүлсэн ба зөвлөмжөөр өгсөн үүрэг даалгаврыг хууль тогтоомж, журмын дагуу мөрдөн ажиллаж байгаа ба зөвлөмжөөр өгсөн үүрэг даалгаврыг хууль тогтоомж, журмын дагуу мөрдөн ажиллаж зөвлөмжийн биелэлтийг холбогдох материалын хамт 6 сард гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан ба Төрийн аудитын байгууллагын мэдээллийн системд оруулан гүйцэтгэлээрх нотлох баримт бичгийг PDF файл болгон оруулан баталгаажуулсан байна.

Хяналтын тооллого , шалгалт хийсэн талаар

НДЕГ-ын даргын 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн А/87 тоот албан бичгийн дагуу “Эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай” ажлын хэсгийг байгуулан хэлтсийн тайланд бүртгэлтэй 7 төрлийн /Барилга байгууламж, Нийтийн эзэмшлийн тохижилт, Авто тээврийн хэрэгсэл, МТТ, ТЭХ, Биет бус хөрөнгө.../ 634.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тоолж, элэгдэл хорогдол, ашиглалтын хугацаа зэргийг хянан баталгаажуулж Төрийн өмчийн бодолго зохицуулалтыг газраас гаргасан маягт хүснэгтийн дагуу мэдээ тайланг хугацаанд нь гарган хүргүүлж “Эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогоор 94 үнэлгээтэйгээр хамгаалсан байна.

Эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгө г.м/ нэгдсэн судалгааны маягтууд ТӨХ /ТӨХ-1-с ТӨХ-11 маягт/ болон мэргэжлийн байгууллагад гаргаж өгдөг мэдээ тайланг хуулийн хугацаанд хүргүүлсэн байна.

Хагас жилийн тооллогоор актлах хөрөнгийн саналыг гарган ТӨБЗГазарт холбогдох баримтыг стандарт маягтын дагуу гарган хүргүүлэн ажиллаа.

Байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн программд өөрчлөлт орсон ба тус программаар жилийн эцэстйн тооллогыг хийж гүйцэтгэн системд оруулан ажилласан байна.

ТАВ. ХАМРАЛТ, ОРЛОГО ШИМТГЭЛИЙН ТАЛААР

Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх

Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулж хамрагдах хүний тоо, орлогын төлөвлөгөөг төсвийг хуваарийг дагуу биелүүллээ.

Нийгмийн даатгалын сангийн орлогын сар, улирал бүрийн төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллаж 2022 онд 141 335.9 сая төгрөгийн шимтгэлийн орлого оруулахаас 136 817.86 сая төгрөгийн шимтгэлийн орлого оруулж 96.8 хувийн биелүүлсэн.



Дэлгэрэнгүй тайланг QR уншуул үзнэ

үү.

Нийгмийн даатгалын хамрагдалт

Нийгмийн даатгал төлдөггүй тодорхой ажил хөдөлмөр эрхлэдэггүй иргэн, малчин хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах, нийгмийн даатгалын ач холбогдол, хууль тогтоомжийг сурталчилан таниулах тэднийг сайн дурын даатгалд хамруулах ажлыг үе шаттай зохион байгуулан ажиллаж байна. Нийгмийн даатгалд хамрагдаагүй ААНБ 2022 онд шинээр 112 аанб бүртгэж албан журмын даатгуулагчийг хамруулсан байна. Өмнөх оны мөн үед 128 аанб хамрагдсан буюу 12,5 хувь буурсан байгаа нь эдийн засгийн хямралтай холбоотойгоор ААНБ үйл ажиллагаа явуулаагүй байна.



Нийгмийн даатгалын хамрагдалтын дэлгэрэнгүй тайланг QR уншуул үзнэ үү.

Өр авлага барагдуулалт

Нийгмийн даатгалын сангийн 2022 оны эхний үлдэгдэл 5139.2 сая төгрөгнөөс 2641.8 мян төгрөг барагдуулж 51.4 хувь бууруулан ажилласан байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 129 537.6 сая төгрөг буюу орлогод эзлэх авлагын хувь 5.1 хувь байна. ХНХСайдын 2018 оны А/99 тоот тушаалыг хэрэгжүүлэн ажиллаж нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг үүссэн хугацаагаар нь ангилах, хянан шийдвэрлэх журмын дагуу

- Уулзалт хийсэн 71 аанб 7.1 сая төг-ийн урсгал авлага
- Гэрээ байгуулсан 82 аанб 6.1 сая төг
- Албан шаардлага өгсөн 48 аанб 488.2 сая төгрөг
- Данс хаасан 28 ААНБ-ын 46.7 сая төгрөг барагдуулсан байна.

Шүүхийн шийдвэр гарсан 33 аж ахуйн нэгж байгууллагын эхний үлдэгдэлтэй 2,615.9 сая төгрөгийн өр авлагаас 756.39 сая төгрөг барагдуулж Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албатай хамтран ажиллалаа.



*Нийгмийн даатгалын өр , авлага барагдуулалтын
дэлгэрэнгүйг QR уншуулж үзнэ үү.*

Тус хэлтэс нь иргэдэд үйчлэх үйлчилгээний “А” хэсэгт 9 улсын байцаагч, угтах болон хариу олгох ажилтан гэсэн бүрэлдэхүүнтэйгээр нийгмийн даатгалын 22 төрлийн үйлчилгээг олон шат дамжлагагүйгээр нэг байцаагчаас авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2022 онд нийт 35971 иргэнд нийгмийн даатгалын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу мэдээлэл зөвлөгөө, үйлчилгээг хүргэн ажилласан байна. Үүнд:

- Тэтгэврийн даатгалын зөвлөгөө, ажилласан жил тооцох, материалын зөрчил шалгуулах 2172
- Тэтгэврийн материал хүлээлгэн өгөх 1549
- Тэтгэвэр авах банкаа өөрчлөх хүсэлт 705
- Тэтгэврийн нэмэгдэл хийлгэх хүсэлт 315
- Ажилгүйдлийн даатгалынх зөвлөгөө 340
- Ажилгүйдлийн тэтгэмжийн материал хүлээлгэн өгөх 950
- Сайн дурын даатгалын зөвлөгөө, тооцоо шалгуулах 5040
- Эрүүл мэндийн даатгалын зөвлөгөө, төлбөр шалгуулах 4591
- Эрүүл мэндийн даатгалын төлбөрийг мэдээллийн санд оруулах 12542 (давхардсан тоогоор)
- Жирэмсэн амаржсаны тэтгэмж авах (СДД) 435
- Хөдөлмөрийн чадвар түр алдсан тэтгэмж (СДД) 451
- Оршуулгын тэтгэмж авах 472
- Архивын лавлагааны хүсэлт 2698
- ААНБ-ын тайлан хүлээн авалт 17136 (давхардсан тоогоор) зэрэг үйлчилгээг тус тус үзүүлэн ажилласан.



*НДХ-ийн хэлтсийн 2022 оны үйлчилгээний
тоон үзүүлэлтийг QR уншуулж үзнэ үү.*

Нийгмийн даатгалын үйлчилгээг сайжруулах, байцаагчийн ёс зүйн харилцааг тодорхойлох, орчин нөхцөлийн тав тухтай байдал, үйлчилгээ авсан иргэдийн сэтгэл ханамж ямар хэмжээнд байгааг үнэлэх зорилгоор үйлчилгээ авч буй иргэдээс өдөр бүр түүврийн аргаар тоон болон чанарын судалгаа авч сар бүр нэгтгэн үйлчилгээгээ сайжруулан ажилласан бөгөөд иргэдийн сэтгэл ханамж жил тутам тогтмол өссөн үзүүлэлттэй байна.



*Сэтгэл ханамжийн судалгааны тайланг
QR уншуулж үзнэ үү.*

№	Байцаагчийн нэрс	Хүлээлгийн хугацааны хувьд:	Тухайн байцаагч таны мэдээллийг бүрэн гүйцэд өгч чадсан уу асуулгын хувьд:	Та байцаагчийн мэргэжлийн чадварыг үнэлэх вэ?	Үйлчилгээ авсан байцаагчийн ёс зүй, харилцаа, хандлагыг та хэрхэн үнэлж байна вэ?	Та байцаагчийн үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай вэ?	Нийлбэр	Индекс
1	Т.Сувд-Оюун	9.15	9.56	8.98	9.37	9.02	46.08	9.22
2	Д.Отгонтуяа	9.1	9.04	8.89	9	8.34	44.37	8.87
3	П.Одонтунгалаг	8.99	9.31	8.42	8.85	8.57	44.14	8.83
4	С.Жавзмаа	8.57	9.2	8.33	8.75	8.69	43.54	8.71
5	Б.Раяа	8.73	8.89	8.27	8.59	8.66	43.14	8.63
6	Н.Хулан	9.06	9.26	8.24	8.23	8.11	42.9	8.58
7	Б.Эрдэнэчимэг	8.23	9.25	8.32	8.64	8.41	42.85	8.57
8	У.Ихзаяа	8.68	9.12	8.47	8.25	8.19	42.71	8.54
9	Э.Батхишиг	7.63	9.18	8.25	8.98	8.39	42.43	8.49


ЗУРГАА. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

1.1 Гадаад сургалт

1.1.1 Малчдад хүргэсэн зөвлөгөө мэдээлэл


- Аймгийн засаг даргын орлогч М.Түмэнжаргалын 2022 оны 02 сарын 10-ны өдөр баталсан Мал аж ахуйн хаваржилт, цаг үеийн ажлаар хөдөө явах удирдамжийн дагуу 2022 оны 02 дугаар сарын 14-ны өдрөөс 2022 оны 02-р сарын 18-ны өдрийг хүртэл, Орхон аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 26 -ны өдөр баталсан мал аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын дагуу 2022 оны 10 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд тус тус нийт 19 чиглэлийн 726 /давхардсан тоогоор/ малчин иргэдэд Малчны тэтгэврийн тухай, 0-3 настай ээжийн сайн дурын даатгал, сайн дурын даатгалын хөнгөлөлт чөлөөлөлтийн мэдээллийг хүргэн тэдний шимтгэл төлж ажилласан жилийн тооцож нийгмийн даатгалын хуулийн мэдээлэл зөвлөгөө хүргэн ажиллаа.
- 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Малчин багийн засаг дарга Баянзулын саналаар Малчин багийн 57 иргэнд нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлэх зөвлөгөө мэдээлэл өгөх ажиллаа.
- 2022 оны 04 сарын 20-ны өдөр Жаргалант суманд зохион байгуулагдсан “Малчин тариаланчдын зөвлөгөөн”-нд оролцсон 170 гаруй малчин тариаланчдад Малчны тэтгэвэр, сайн дурын даатгал, эрүүл мэндийн даатгалын тухай мэдээлэл хүргэн ажилласан.

МАЛЧИН



1.1.2 Аж ахуй нэг байгууллагад хийсэн цахим сургалт

2022 онд 16 удаагийн сургалтаар **206** аж ахуй нэгж байгууллагын **4978** даатгуулагчдад Нийгмийн даатгалын ерөнхий ойлголт, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль, цахим үйлчилгээний цахим тайлан, тоон гарын үсгээр тайлан илгээх зэрэг асуудлаар сургалт мэдээлэл хүргэлээ.



1.1.3 Тусгай хэрэгцээт иргэдэд хүргэсэн мэдээлэл үйлчилгээ

- Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар 7 хоног бүр орж хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоолгож буй иргэдэд биечлэн очиж сургалт мэдээллийг тогтмол хүргэн ажиллаж байна. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоолгосон, сунгуулсан иргэд сунгалтын болон тогтоолтын актаа барин ирж тэтгэвэр, эрүүл мэндийн даатгалаа сунгуулах зэрэг үйлчилгээг авахаар нийгмийн даатгалын хэлтэст ирдэг. Хурал дээр биечлэн очисноор даатгуулагч нийгмийн даатгалын хэлтсээр очих шаардлагагүйгээр үйлчилгээгээ нэг дороос авах боломжийг бүрдүүлэн ажиллаж сургалт мэдээллээ хүргэн ажиллаж хэвшээд байна.

Эхний хагас жилийн байдлаар нийт **40** удаагийн хурлаар **3116** иргэнд мэдээлэл хүргэн ажилласан байна.

Эхний хагас жилийн байдлаар нийт **40** удаагийн хурлаар **3116** иргэнд мэдээлэл хүргэн ажилласан байна.



- Аймгийн засаг даргын тамгын газраас зохион байгуулсан “хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжил оролцоо” сэдэвт нэгдсэн арга хэмжээнд оролцсон **210** иргэн болон тэдний асран хамгаалагч нарт нийгмийн даатглын тухай хуулиар дэлгэнгүй мэдээлэл өгч тараах материалаар хангаж ажиллаа.
- Орхон аймаг дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны гаргасан хүсэлтийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, ҮОМШӨ-ний тухай хуулийн мэдээллийг хүргэж иргэдийн асуусан асуултанд хариулт өгч ажиллаа. Уг сургалтанд **28** иргэн оролцсон.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, Хөдөлмөр эрхлэхэд учирч буй саад бэрхшээлийг багасгах, хөдөлмөрлэх чадвар, ЭХМК-ын үйл ажиллагааны чиглэл хувь хугацаа тогтоох, иргэний зүгээр анхаарах асуудлын талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл болох **28** иргэнд магадлагч эмч Д.Пүрвээ, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн О.Чойенмаа нар мэдээлэл өглөө.
- Жижиг дунд бизнес эрхлэгч иргэдийн төсөл хөтөлбөрийг дэмжин ажилладаг Best хөтөлбөрийн санаачлагаар жижиг дунд бизнес эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй **32** иргэнд шимтгэл төлөгж аж ахуй нэгж байгууллагаар бүртгүүлэх, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан илгээх, тахир дутуугийн тэтгэвэр, сайн дурын даатгалын тухай мэдээлэл бэлтгэн хүргэлээ.



Гадаад сургалтын дэлгэрэнгүйг QR уншуулж үзнэ үү.



Дотоод сургалт

Хэлтсийн даргын батласан удирдамжийн дагуу дотоод сургалтыг хуваарийн дагуу танхим болон цахим хэлбэрээр зохион байгууллаа. Нийгмийн даатгалын хэлтсийн байцаагч, төлөөлөгчдийг чадавхжуулах, ярих, илтгэх чадварыг сайжруулах, хуулийн мэдлэг олгох, шинэ ажилтныг сургахад сургалтын зорилго оршино. Сургалтын үр дүнд байцаагч, төлөөлөгчдийн хуулийн мэдлэг дээшилж хуулийн талаарх нэгдсэн ойлголттой болж, ярих ур чадвар нэмэгдсэнээр иргэд даатгуулагчдад мэдээллийг ойлгомжтой хүргэж тэдний сэтгэл ханамж дээшилнэ. Уг **80** удаагын сургалтанд давхардсан тоогоор **766** байцаагч ажилтан оролцлоо. Сургалтын хуваарийг бэлтгэн, үйл явц, үр дүнг хянан нэгтгэж, тухай бүр сургалтаар олгосон мэдлэгийг бататгах шалтгалт авч ажилласан. Ингэснээр сургалтын үр дүнд нийт төлөөлөгчдийн илтгэх, ярих, сургалтын материал стандартын дагуу хөтлөх, сургалт зохион байгуулах чадвар сайжирч байна. **7** удаагийн мэдлэгээ баталгаажуулах шалгалт авч давхардсан тоогоор **68** ажилчид оролцсон. Шалгалтын дундаж оноо нь **92,6%**-ийн үзүүлэлттэй байна.



Дотоод сургалтын дэлгэрэнгүйг QR уншуулж үзнэ үү.



Нийгмийн маркетинг

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс фэйсбүүк, пэйж хуудас нь 17382 гаруй дагагчтай ба фэйсбүүк, пэйж хуудсаараа дамжуулан иргэд, даатгуулагчиддаа тогтмол мэдээ мэдээллийг хүргэн ажилладаг бөгөөд Тэтгэвэр, тэтгэмж, сайн дур, эрүүл мэнд, ажилгүйдлийн даатгалын талаарх мэдээлэл гэх мэт цаг үеийн холбоотой Нийгмийн даатгалын тухай өөрчлөлт, шинэчлэлтийн талаарх мэдээллийг бэлтгэн нийтэлдэгээс гадна холбогдох байгууллагын /НДЕГ/ мэдээллийг цаг тухай бүр хүргэж ажилладаг. Мөн 7 хоногт 2 удаа фэйсбүүкийн шууд нэвтрүүлэг хийн, иргэд даатгуулагчиддаа хэрэгтэй мэдээллийг хүргэж, шууд асуултанд хариулт өгч цахим мэдээллийн хэрэгслээр дамжуулан, иргэдийн цаг хугацаа хэмнэн ажиллаж байна.



Маркетингийн тайлангийн дэлгэрэнгүйг QR уншуулан үзнэ үү.

Call center, call back үйлчилгээ

Даатгуулагч иргэдэд өдөр тутамдаа **Call center** үйлчилгээ буюу утсаар мэдээлэл зөвлөгөө өгөх үйлчилгээг хүргэдэг бөгөөд энэ иргэдээс нийт **19261** ирсэн байна. Давхар дуудлага ирэх, тог тасрах сүлжээ доголдох болон ажлын ачааллаас шалтгаалан дуудлага алдах тохиолдол байдаг. **7577-6699**

Тэгвэл төрийн үйлчилгээнд анх удаа алсан дуудлага бүрт эргэж холбогдон хариу өгөх үйлчилгээг нэвтрүүллээ. Энэ онд 3950 дуудлага алдсан байна. Эдгээр алдсан дуудлага бүрлүү 100% эргэж холбогдон хариу өгч ажиллаа. Цаашид дуудлага алдалтын хувийг багасгах зорилготой ажиллаж байна.

Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор иргэдэд утсаар мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулан ажиллаа. Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас “Цалинтай ээж хөтөлбөр”-т хамрагдаж байгаа ээжүүдийн судалгааг авах, ажилгүйдлийн сангаас тэтгэмж авч байгаа тэтгэмж авагч, Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тогтооход эрх үүсээгүй буй ажилласан жилийн болзол хангагдаагүй иргэд болон нийгмийн даатгалын шимтгэлийн 50%-ийг буцаан олгоход дансны мэдээлэл зөрүүтэй иргэдрүү утсаар холбогдон мэдээлэл түгээн ажиллаа.

Энэхүү утсаар мэдээлэл түгээх ажил маань иргэдийн явдал чирэгдлийг багасгах мөн нийгмийн даатгалын байцаагчийн ажлын ачааллыг бууруулах, хамралтыг нэмэглүүлэх чиглэсэн ажил юм.



Тайлангийн дэлгэрэнгүйг QR уншуулан эндээс үзнэ үү.



Нийгмийн даатгалын төлөөлөгч

Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх, иргэдийг эрсдэлээс хамгаалах, нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, аж ахуйн нэгж, иргэдийг илрүүлэх, Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг иргэд, даатгуулагчдад сурталчлах таниулах, нийгэмд зөв дадал хэвшил бий болгож, нийгмийг соён гэгээрүүлэх зорилгоор нийгмийн даатгалын менежментийг сайжруулах зорилгоор 2017 оноос Нийгмийн даатгалын төлөөлөгч төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.



Нийгмийн даатгалын төлөөлөгчдийн тайлангийн дэлгэрэнгүйг QR уншуулан үзнэ үү.

Сэтгэл ханамжийн судлагаа

Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээг сайжруулах даатгуулагч, иргэдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зорилгоор эхний хагас жилийн байдлаар 1836 иргэдийг сэтгэл ханамжийн судалгаанд хамруулан ажиллаа. Үйлчлүүлж буй иргэдээс авах судалгаанаас гадна цахимаар үйлчилгээ авсан даатгуулагч нараас сэтгэл ханамжийн судалгаа авах мөн нийгмийн даатгалын тухай хуулийн сургалтанд хамрагдсан даатгуулагч шинээр судалгаа аван ажиллаж байна.

1. Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйлчилгээг сайжруулах, иргэдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх зорилгоор 2022 онд тус хэлтсээр үйлчлүүлсэн иргэдээс түүврийн аргаар нийт **3526** иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авч нэгтгэн ажиллаа. Нийгмийн даатгалын хэлтсээр үйлчлүүлсэн **3526** иргэнийг түүвэрлэн судалгаан хамруулж нийгмийн даатгалын үйлчилгээг бүрэн гүйцэд, ойлгомжтой хүргэж байгаа эсэх, иргэдийн хүлээлтийн хугацааг тодорхойлох, байцаагчдын ёс зүйн харилцааг тодорхойлох, үйлчилгээ авахад орчин нөхцөлийн тав тухтай байдал, үйлчилгээ авсан иргэдийн сэтгэл ханамж ямар хэмжээнд байгааг үнэлэх зорилгоор судалгаа авч ажиллаа.
2. Ковид цар тахлын улмаар цахимаар зөвлөгөө мэдээлэл авах даатгуулагчийн тоо эрс нэмэгдсэн байгаа. Үүнтэй холбоотой цахим үйлчилгээг илүү сайжруулан ажиллаж цахимаар үйлчилгээ авч байгаа иргэдээс үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн судалгааг авч эхлээ байна. Энэ онд **501** иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авч нэгтгэн ажиллаа.
3. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар орж хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоолгож буй иргэдээс ЭХМК-ны үйлчилгээг үнэлэх зорилгоор сэтгэл ханамжийн судалгаа авдаг. Хагас жилийн байдлаар **523** иргэнээс судалгаа авч нэгтгэн ажиллалаа.



Сэтгэл ханамжийн судалгааны дэлгэрэнгүйг QR код уншуулан үзнэ үү.


Чатбот буюу автомат хариулагч



Орхон аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн цахим хуудсандаа чат бот буюу автомат хариулагчийн үйлчилгээг шинээр нэвтрүүлсэн ба энэ үйлчилгээ нь иргэд даатгуулагчийн сэтгэлд нийцсэн үйлчилгээ болоод байна. Автомат хариулагчаас тогтмол мэдээлэл авдаг 5277 даатгуулагч байгаа бөгөөд давхардсан тоогоор 8734 гаруй удаа чат бод үйлчилгээнд хандаж мэдээлэл авсан байна. Иргэнээс ирсэн асуултад хариулт өгч нийт 456 орчим материалыг цахимаар хүлээн авч ажиллаа. Сайн дурын даатгалын гэрээ байгуулах хүсэлтийг хүлээн авч даатгуулагчийн иргэний үнэмлэхний хуулбарыг хувиалан гэрээ байгуулж цахим үйлчилгээ үзүүллээ. Энэ нь иргэд даатгуулагчийг өөрийн биеээр ирүүлэхгүй цаг хугацаа хэмнэх Үйлчилгээний А хэсгийн ачааллыг багасгасан иргэд, даатгуулагчдын сэтгэлд нийцсэн таатай үйлчилгээ боллоо.



Цахим дагагчийн тоо 18.000



Цахимаар хүлээн авсан
материалийн тоо **456**
Чат ботоос тогтмол
мэдээлэл авдаг
даатгуулагчийн тоо **5277**

Чат ботоос мэдээлэл авсан
даатгуулагч **8734**

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх ЭХМК нь Засгийн газрын 2021 оны 67 тогтоолоор батлагдсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссийн дүрэм” 2017 оны 01 сарын 26-ны өдрийн А/39 А/12 тоот “Иргэн /даатгуулагч/-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг шинэчлэн батлах тухай ЭМСайд, ХНХС-ын хамтарсан тушаалыг хэрэгжүүлэн ЭХМК, ЭХК-ын хурал сар болгоны долоо хоног бүрийн пүрэв гарагт хуралдаж байна.

Нэг удаагийн хурал нь дундажаар 70-100 иргэний ХЧА-ын хувь, хугацааг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцлийг өөрчлөх шийдвэр гарган ажилласан байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар нийтдээ 45 удаа хуралдаж, 3491 иргэн даатгуулагч орсноос 171 иргэн шинээр ХЧА-ын хувь хугацаа тогтоолгож, 199 иргэний ХЧА-ын хувь хугацаа тогтоосон шийдвэрийг цуцалжээ. Мөн шилжиж ирсэн 25, шилжиж явсан 29, нас барсан 59, үйлдвэрлэлийн осол 63 байна.

Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын хуралд хурлын гишүүд хуралдаа хариуцлагатай, тогтмол оролцож хурлын ирц дундажаар 80% - 89%-ийн бүрдэлтэй хуралдаж байв. 2021 онд ЭХМК-ын гишүүдийн тоо Монгол улсын засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын тогтоолоор нэмэгдэж 10 хүний бүрэлдхүүнтэй болсон ба үйлдвэрчний эвлэлийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөлтэй хуралддаг болсон.

2022 оны жилд ЭХМКомисс нь 45 удаа хуралдаж:

- ✓ Хөдөлмөрийн нөхцөл сольсон 3 нийт 3 даатгуулагч
- ✓ ХЧТА-ын хувь хугацаа тогтоосон – 171
- ✓ ХЧТА-ын хувь, хугацааг сунгасан - 3428
- ✓ ХЧТА-ын хувь, хугацааг цуцалсан - 199
- ✓ Шилжиж ирсэн - 25
- ✓ Шилжиж явсан - 29
- ✓ Нас барсан – 59
- ✓ Нийт- 3491 иргэн байна.



*Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дэлгэрэнгүй
тайланг QR уншуулж үзнэ үү.*

ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС